



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/117

Арвайхээр сум

### Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналт тавих” 43 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд чанартай зохион байгуулах тухай” 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүргийг халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд, 2023 оны төлөвлөгөөт халдваргүйтгэл, “Хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн аян”-ыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс аймгийн хэмжээнд тус тус зохион байгуулсугай.

2. Мал, амьтны гоц халдварт өвчин гарсан тохиолдолд сумын Засаг дарга, төрийн байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, мэргэжлийн анги томилон ажиллах боломжоор хангах, холбогдох хууль, журам заавар, стандартыг мөрдөх, отрын бүс нутгаас буцаж ирэх, дамжин өнгөрөх малын шилжилт хөдөлгөөний үед зөвлөн туслах, хяналт тавих үүрэг бүхий хяналтын цэг ажиллуулах, мал, амьтны сэг зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах зардлыг шийдвэрлэж, тайлан мэдээг хугацаанд нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Мал эмнэлгийн газарт сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулагдах тарилгыг цаг хугацаанд нь татан авч, хувийн мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүдэд хүргэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц, чанар үр дүнтэй уялдуулан санхүүжилт олгох, малын шилжилт хөдөлгөөн отор нүүдэлд мал эмнэлгийн хяналт тавих, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0188

D:My Doc. Zahiramj. Zasag darga